



МОНГОЛ УЛСЫН
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ
ТОГТООЛ

2020 оны 3 сарын 19 өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

Мэдээллийн технологийн багийн гишүүн, даамлын сургалт явуулах,
гэрчилгээ олгох журам батлах тухай

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.3 дахь хэсэг, Аймаг, нийслэл сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.3 дахь хэсэг, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооноос ТОГТООХ нь:


1. "Мэдээллийн технологийн багийн гишүүн, даамлын сургалт явуулах, гэрчилгээ олгох журам"-ыг 1 дүгээр хавсралтаар, "Мэдээллийн технологийн багийн гишүүн, даамлын сургалтад хамрагдах төрийн албан хаагчдын мэдээллийн маяг"-ыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү журмын хэрэгжилтийг хангуулж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг Хорооны нарийн бичгийн дарга /Ц.Болдсайхан/-д даалгасугай.

ДАРГА *Ц. Сойм* Ч/СОДНОМЦЭРЭН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА *Ц. Болдсайхан* Ц.БОЛДСАЙХАН



Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны
2020 оны 3 дугаар сарын 19-ны өдрийн
11... дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт



МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН БАГИЙН ГИШҮҮН, ДААМЛЫН СУРГАЛТ ЯВУУЛАХ, ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Мэдээллийн технологийн баг /цаашид “баг” гэх/-ийн гишүүн, мэдээллийн технологийн даамал /цаашид “даамал” гэх/-ын сургалт /цаашид “сургалт” гэх/ явуулах, гэрчилгээ олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2.Сургалтад төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагч хамрагдах бөгөөд Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн төв /цаашид “төв” гэх/ энэ журамд заасны дагуу сургалтыг зохион байгуулж, гэрчилгээ олгоно.

Хоёр.Сургалтад хамрагдах төрийн албан хаагчдын мэдээлэл хүлээн авах, бүртгэх

2.1.Төв сургалтад хамрагдах төрийн албан хаагчдын мэдээллийг баталсан маягтын дагуу хүлээн авч, бүртгэл хөтөлнө.

2.2.Сургалтад хамрагдах төрийн албан хаагчдын мэдээллийг тухайн албан хаагчийн иргэний үнэмлэх, төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалд томилсон шийдвэрийн хуулбарын хамт дараах байдлаар Төвд ирүүлнэ:

2.2.1.аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал багийн гишүүний сургалтад хамрагдах албан хаагчдын мэдээллийг цахим хэлбэрээр;

2.2.2.баг нь даамлын сургалтад хамрагдах албан хаагчдын мэдээллийг цаасан эсхүл цахим хэлбэрээр.

2.3.Баг энэ журмын 2.2.2-т заасан мэдээллийг ирүүлэхдээ

- сумын нутаг дэвсгэрт харьяалагдах 8 хүртэл хэсэг тутамд 1 даамлын нөөцтэй байхаар;
- дүүргийн нутаг дэвсгэрт харьяалагдах 10 хүртэл хэсэг тутамд 1 даамлын нөөцтэй байхаар тооцно.

2.4.Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагч сургалтад хамрагдах хүсэлтээ Сонгуулийн ерөнхий хорооны цахим хуудсанд хандан гаргаж болно.

2.5.Төв энэ журмын 2.2, 2.4-т заасан мэдээллийг цаасан болон цахим хэлбэрээр зохих журмын дагуу хадгална.

Гурав.Сургалт явуулах, гэрчилгээ олгох

3.1.Төв сургалтын хөтөлбөрийг хууль, тогтоомжид нийцүүлэн боловсруулж батална.

3.2.Сургалтыг батлагдсан хөтөлбөрийн дагуу зохион байгуулж, хамрагдсан албан хаагчдад гэрчилгээ олгоно. Даамлын сургалтыг зохион байгуулахад баг хамтран ажиллана.

3.3.Сургалтыг зохион байгуулахад тухайн шатны сонгуулийн хороо, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал сургалтын танхим, шаардлагатай техник хэрэгслээр хангана.

3.4.Баг, даамлын гэрчилгээ нь нэгдсэн дугаартай байх ба гэрчилгээг гээгдүүлж үрэгдүүлсэн тохиолдолд өмнө олгосон гэрчилгээг хүчингүйд тооцож, нэг удаа нөхөн олгоно.

Дөрөв.Хариуцлага

4.1.Сонгуулийн тухай хууль тогтоомж болон энэ журамд заасныг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---

Улсын Сонгуулийн Ерөнхий
ны 3 дугаар сарын 19-ны ө
гаар тогтоолын 2 дугаар ха

ХАМРАГДАХ

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН БАГИЙН ГИШҮҮН, ДААМЛЫН СУРГАЛТАД ХАМРАГДАХ

[illegible]